

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД НӨЛӨӨЛЖ БУЙ УЛС ТӨРИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДРУУЛАХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Төрийн бодлогод эрх ашиг нь хөндөгдөж буй болон сонирхогч талын санаа бодол, байр суурийг сонсох, бодлогод харгалзан үзэхийг эрмэлзэх нь ардчилсан төрийн нийтлэг зарчим бөгөөд тэднийг сонсох энгийн арга зам нь бодлогын үйл явцад оролцуулах явдал юм. Төрийн бодлого нь боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх түвшинд олон үе шат, оролцогчоор дамжиж байдаг. Бодлогын хамрах цар хүрээ, ач холбогдол, зорилгоос хамаарч бодлогод оролцогчдын хүрээ тодорхойлогдох нь ойлгомжтой хэдий ч бодлогын үйл явцад ялангуяа бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцад иргэд оролцох нь тэдний улс төрийн эрхээр тодорхойлогдоно. Монгол улсын хувьд иргэн төрийн үйл хэрэгт оролцох эрхтэй бөгөөд түүнийг нь Үндсэн хуулиар баталгаажуулсаны сацуу ардчилсан ёс төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болдог¹.

Төрийн бодлогод олон нийтийн санаа бодлыг тусгаснаар бодлого хэрэгжих таатай орчин бий болж цаашид хөгжих эхлэл тавигдах юм. Иймээс гадаадын хөрөнгө оруулалтын талаарх бодлого, түүний орчныг судлахдаа олон нийтийн санаа бодлын судалгааг боловсруулан судалсан.

Судалгааны зорилго: Гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, нийгмийн өмнө тулгамдсан ажлын байр нэмэх, ажиллах боловсон хүчнийг чадавхжуулах, орлогын түвшинг дээшлүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд голлох үүргийг гүйцэтгэж байна. Иймээс гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлогод гол нөлөө үзүүлж буй хүчин зүйлийг олж тогтоох, цаашид ямар асуудалд анхаарвал зохих талаар тодруулах зорилготой.

Судалгааны үндэслэл, шаардлага:

Гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал нь судлаачид, биенес эрхлэгчдийн нүдээр ямар хүчин зүйлээс үүдэн хөрөнгө оруулалтын хэмжээ буурч эдийн засагт үзүүлэх нөлөө багасаж буйг тодруулан үүнд улс төрийн хүчин зүйлийн нөлөө хэр байгааг тодорхойлж судалгааны ажлын бааз мэдээлэл болгон үүн дээр тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтын талаарх

¹ Бямбажав.Д. (2006). Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-н оролцоо: Эрхзүйн орчин болон институтчиллийг сайжруулах нь. Нээлттэй нийгэм форум.

бодлогын улс төр, эрхзүйн орчинг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай байна.

Судалгааны арга зүй

Эх олонлог: Судалгааны эх олонлогийг Монгол улсын 25 ба түүнээс дээш насны иргэд байхаар сонгон авсан нь судалгаанд бодитой мэдээлэл өгөхийг иш үндэс болгосон.

Түүврийн хүрээ: Гадаадын хөрөнгө оруулалтын үр дүн нь шууд нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй холбодон түүний талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэлт нь улс төрийн бодлого, эдийн засгийн бодлого, түүний өсөлт, хөгжил зэрэгтэй нягт уялдаатай байдаг учраас түүврийн хүрээг сонгохдоо гадаадын хөрөнгө оруулалтын талаар судалдаг, түүнтэй холбоотой ажил эрхэлдэг, тодорхой түвшинд мэдлэгтэй хувиараа бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжийн удирдлага, иргэдээс улс төр, эдийн засаг, бусад (гадаадын хөрөнгө оруулалтын талаар тодорхой түвшинд мэдлэгтэй иргэд, бусад судлаачид гэх мэт) гэсэн хэлбэрээр авсан.


Хүснэгт 7. Түүврийн хүрээ ба эх олонлогийн хэмжээ

Түүврийн хүрээ	Сонгогдсон мэргэжил/алба/ажил	Эх олонлог
Улс төр	Улс төр судлаач	
	Улс төрч	
Эдийн засаг	Эдийн засагч	1,690,873
	Бизнесмен	
Бусад	Бусад	

Түүвэр олонлог: Түүврийн оновчтой хэмжээг сонгох олон аргачлал байдаг хэдий ч практикт хамгийн өргөн ашиглагддаг, түүвэрлэлтийн үндсэн таамаглал нь эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзэх, энгийн санамсаргүй түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг сонгож, томъёог доор үзүүлэв.

$$n = \frac{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}{\Delta_p^2}$$

Энд, t = Студентийн t тархалтын критик утга; w = түүврийн тодорхой асуултанд хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь. Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогтмол хэмжээг ашигладаг; N = эх олонлогийн хэмжээ; Δ = алдааны хязгаар буюу түүврийн үр дүнд гарсан дундаж утга нь түүврийн хэмжээг Δ хувиар ихэсгэж, бууруулсан ч үр дүн нь ижил гарна гэсэн таамаглал юм.



Өгөгдөл	Утга	Тайлбар
t	1.96	95%-ийн итгэх магадлалын түвшин
w	0.5	Тогтмол утга
N	1,690,873	Эх Олонлог 25 наснаас дээшх Монгол улсын хүн амын тоо
Δ	0.05	Алдааны хязгаар
n	552	Оновчтой түүврийн хэмжээ


Судалгааны эх олонлог болох 25 наснаас дээш Монгол улсын хүн амын тоо болох 1,690,873 (Статистикийн Хороо, Хүн ам орон сууцны тооллого, 2016) иргэдээс 95%-ийн итгэх магадлалтай, +/-5-ийн алдааны хязгаартай байхаар тооцвол эх олонлогийг төлөөлөх боломжтой түүвэр хэмжээ 552 (Advisors, 2006) иргэд /төлөөлөл/ байхаар тооцоологдож байна. Иймээс тус судалгаанд нийт 552 иргэдийг хамруулсан түүврийн хүрээнд судалсан болно.

Мэдээлэл боловсруулалт: Судалгааны мэдээллийг боловсруулахдаа Microsoft Excel 2010 программ дээр хийж, үр дүнг тайлбарлан гаргасан. Судалгааг социологийн судалгааны анкетийн аргаар авсан. Энэхүү судалгааны үр дүн гадаадын хөрөнгө оруулалтын талаарх орчныг сайжруулах ажилд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.


Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Судалгаанд нийт 552 иргэд хамрагдсанаас 59% буюу 325 эрэгтэй, 41% буюу 227 эмэгтэй иргэд байсан. Нийт оролцогчдын 30% эдийн засагч, 15% улс төр судлаач, 7% улс төрч, 36% бизнесмен, 12% бусад мэргэжилтэй, 6,9% нь дунд, 93,1% нь дээд боловсролтой иргэд байсан. Судалгаанд оролцогчдыг насны хувьд авч үзвэл 43,1% нь 25-35 настай, 32,8% нь 36-45 настай, 22,4% нь 46-55 настай, 1,7% нь 56-с дээш настай иргэд байсан.


Судалгааны асуулт




Судалгаанд хамрагдагсдын 19% нь гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдлыг сайн гэж үзсэн бол 53.4% нь дунд, 15.5% муу, 12.1% нь хангалтгүй гэж үзжээ. Нийт дүнгээр тооцвол 81% нь гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдлыг дунд түүнээс доогуур түвшинд байна гэж үзжээ.



Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн ихэнх нь буюу 36.2% нь гадаадын хөрөнгө оруулалтын орчин, нөхцөл байдлыг өмнөх оныхоос муудсан гэж үзсэн байна. Харин 29.3% нь хэвээрээ буюу гадаадын хөрөнгө оруулалтын орчин, нөхцөл байдал өөрчлөгдөөгүй, дээрдсэн зүйлгүй гэж үзсэн бол 19% нь өмнөх онтой харьцуулахад сайжирсан байна гэж үзжээ. Тэгвэл 15.5% нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн нь өөрчлөгдсөн зүйл бараг ажиглагдахгүй буйг илтгэж байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.




Гадаадын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн өмнө тулгамдсан ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах боловсон хүчнийг чадавхжуулах, орлогын түвшинг дээшлүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд голлох үүргийг гүйцэтгэдэг тухай өмнөх бүлэгт дурдсан. Үүнийг судалгаагаар харвал гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг өндөр гэж нийт судалгаанд оролцогчдын 55.2% нь, маш өндөр гэж 15.5% нь хариулжээ. Нийт дүнгээр гадаадын хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг 70.7% нь өндрөөр үнэлсэн бол тааруу, огт хэрэггүй гэж 12% нь үзсэн байна. Энэ асуулгын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд гарах үр дүн нийгэм, эдийн засагт эерэгээр нөлөөлдөг болох нь харагдаж байна.



Дээрх асуултад гадаадын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд гарах үр дүнг 70.7% нь өндрөөр үнэлсэн. Тэгвэл гадаадын хөрөнгө оруулалт хэрэгжсэнээр үүсэн бий болох нөхцөл байдлыг 82.8% нь эдийн засгийн өсөлт бий болж өрхийн орлого нэмэгдэнэ гэж үзсэн бол 27.6% нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө бий болно, 17.2% авлигал, хээл хахууль цэцэглэн

хөгжнө гэж үзсэн нь улс төрийн хүчин зүйлийг багтаасан байна. Харин 27.6% нь өөр бусад нөхцөл байдал үүснэ гэж үзсэн.

Эндээс харвал иргэд гадаадын хөрөнгө оруулалтыг эсэргүүцдэг биш, зөв зохистой хэрэгжүүлвэл оруулах ёстой гэдэгт дийлэнх нь итгэж байна. Гэхдээ үүнийг зөв хэрэгжүүлж чадах эсэхэд эргэлзэх байдал ч өндөр хувьтай байна.




Гадаадын хөрөнгө оруулалт хэрхэн улс төртэй, улс төрийн хүчин зүйлстэй холбогддог болохыг тодруулбал, гадаадын хөрөнгө оруулалт нь төрийн бодлогын чухал хэсэг учраас гэж 48.3%, түүний санхүүжилт улс төрчдийн анхаарлыг татдаг учраас гэж 43.1%, олон төрлийн тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг төрийн байгууллагаас авдаг учраас гэж 37.9%, нийгэм, эдийн засагт ихээхэн нөлөөтэй байдаг учраас гэж 27.6% нь хариулсан байна. Үүнээс харахад гадаадын хөрөнгө оруулалтын талаарх бодлого төрийн бодлогын зайлшгүй хэсэг болох нь, түүний санхүүжилт олны анхааралд ялангуяа улс төрчдийн анхааралд байдаг нь харагдаж байна.

6. Сүүлийн 5 жилд ГХО буурч буй шалтгааныг юу гэж дүгнэх вэ? /1-4 хариулт/



2012 оноос гадаадын хөрөнгө оруулалт буураад буй шалтгааныг олж тогтоохын тулд энэхүү асуулгыг асуусан. Шалтгааныг судалгаанд хамрагдагсдын 72.4% нь улс төрийн нөхцөл байдал тогтворгүй болсон учраас гэж хариулсан бол дотоодын эдийн засгийн өсөлт саарч, гадаадын хөрөнгө оруулалтыг татах орчин муудсан гэж 34.5%, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал муудаж, түүхий эдийн эрэлт буурсан 32.8%, хууль эрх зүйн байдлаас болж гадаадын хөрөнгө оруулалтын урсгал буурч байна гэсэн харилуцыг 29.3% нь өгсөн байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, түүхий эдийн үнэ дэлхий нийтэд буурч эрэлт саарсныг эс тооцвол гадаадын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал буурах шалтгаан дотоодын эдийн засаг, хууль эрхзүй, улс төрийн нөхцөл байдлаас хамаарч буй нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Эдгээр нөхцөл байдлыг зохицуулах гол зохицуулагч нь улс төрийн бодлого, улс төрийн хүчин зүйл юм.

7. Хэрвээ ГХО улс төрийн нөхцөл байдлаас болоод буурсан бол тухайлсан ямар ямар хүчин зүйлс нөлөөтэй гэж үзэж байна вэ? /1-4 хариулт/



Гадаадын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал буурах гол шалтгаан нь улс төрийн нөхцөл байдал бол тухайлсан ямар хүчин зүйл чухал нөлөөтэйг авч үзье. Засгийн газрын тогтворгүй байдал гэж 55.2%, улс төрийн фракцуудын ашиг сонирхол 39.7%, Улсын их хурал, Засгийн газрын гишүүдийн үйл ажиллагаа муу гэж 37.9% нь, хувь улс төрчдийн ашиг сонирхол 29.3%, улс төрийн намын эрх ашиг гэж 25.9% нь хариулсан байна.



Гадаадын хөрөнгө оруулалт буурах шалтгаан нь улс төрийн хүчин зүйл тэр дундаа засгийн газрын тогтворгүй байдлаас болж байна гэсэн хариулт 55.2% байсан бол түүнд улс төрийн ямар хүчин зүйл, үзүүлэлт чухал нөлөөтэй вэ гэсэн асуултад засгийн газрын тогтвортой байдал гэж 74.1% нь үзсэн нь гадаадын хөрөнгө оруулалтын орчин, түүнийг татах бодлогод засгийн газрын үйл ажиллагаа, түүний тогтвортой байдал хамгийн чухал нөлөө үзүүлдэг улс төрийн хүчин зүйл болох нь харагдаж байна. Улс төрийн намын фракцуудын ашиг сонирхол гэсэн хариултыг 53.4% өгсөн нь улс төрийн намын доторх хагарал, фракцын байр суурь, тэдгээрийн ашиг сонирхлын зөрчил, сонирхол чухал нөлөөтэйг илтгэж байна. Дараагийн чухал улс төрийн хүчин зүйл бодлогын залгамж холбоотой байдал гэж 51.7% нь хариулсан байна. Үүний дараа авлигал гэж 43.1%, хувь улс төрчийн ашиг сонирхол гэж 37.9% нь хариулсан байна.

9. Таны бодлоор ГХО-ыг татахад нэн тэргүүнд ямар ажил хийх хэрэгтэй вэ? /1-4 хариулт/



Гадаадын хөрөнгө оруулалтын буурах шалтгаан, түүнд нөлөөлөх гол хүчин зүйл нь улс төрийн хүчин зүйл гэсэн хариултууд дээрх судалгааны асуултуудаас харагдаж байна. Тэгвэл гадаадын хөрөнгө оруулалтыг татахад нэн тэргүүнд ямар ажил хийх хэрэгтэйг харвал гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай болох гэж 44.8%, Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, Засгийн газрын тогтвортой байдлыг хангах гэсэн хариултыг тус тус 43.1%, Засгийн газрын үйл ажиллагааг идэвхжүүлэх 37.9%, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг сайжруулах гэж 34.5% нь хариулсан байна.

Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн ихэнх нь гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэртэй хүчин зүйл гэж үзсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал муу, хангалтгүй хэмжээнд ажиллаж байгааг онцлоод түүний гол шалтгаан нь улс төрийн хүчин зүйлс нарийвчилбал, улс төрийн тогтворгүй нөхцөл байдал гэж үзсэн. Гадаадын хөрөнгө оруулалтад улс төрийн хүчин зүйлс нөлөөлдөг талаар судалгаанд оролцогчид үзэхдээ гадаадын хөрөнгө оруулалт нь төрийн бодлогын чухал хэсэг, түүний санхүүжилт улс төрчдийн анхаарлыг татдаг учраас улс төртэй холбогддог гэж хариулсан байна. Гадаадын хөрөнгө оруулалт буурах голлох шалтгаан нь хэрэв улс төрийн тогтворгүй нөхцөл байдал гэж үзэж буй бол тухайлсан ямар хүчин зүйлс нөлөөлж буйг тодруулахад засгийн газрын тогтворгүй байдал, бодлогын залгамж холбоогүй байдал, улс төрийн намын эрх ашиг түүн дотор улс төрийн намын фракцын ашиг сонирхол, хувь улс төрчийн ашиг сонирхол, УИХ, ЗГ-ын үйл ажиллагаа муу байгаа зэрэг нь чухал нөлөө үзүүлж байна гэж үзсэн. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад нэн тэргүүнд гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай болох хэрэгтэй гээд

засгийн газрын тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг сайжруулах хэрэгтэй гэж үзсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдэх, эсвэл буурах нь засгийн газрын үйл ажиллагаа тогтвортой, тогтворгүй байхаас шууд хамаарч байна. Засгийн газрын үйл ажиллагаа тогтвортой байх уу, тогтворгүй байх уу гэдэг нь улс төрийн намын фракцуудын ашиг сонирхлоос ихээхэн хамаарч байна. Энэ нь хувь улс төрчийн ашиг сонирхол нь улс төрийн намын фракцуудан ашиг сонирхолд шууд нөлөөлж буй логик холбоос харагдаж байна. Өөрөөр хэлбэл нэг хүний ашиг сонирхлын зөрчил нь улс төрийн нөхцөл байдал тогтворгүй болоход нөлөөлж байна. Энэ нөлөөллийг багасгаж, арилгах нь дараагийн том бүлгийн эрх ашгийн зөрчлийг бууруулах эерэг нөлөөтэй.

Ашиг сонирхлын зөрчил гэдгийг Монгол Улсын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.2-т "хувийн ашиг сонирхол" гэж нийтийн албан тушаалтан² албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг; 3.1.3-т "ашиг сонирхлын зөрчил" гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг хэлнэ гэж заасан байдаг. Гэтэл улс төрчийн, улс төрийн намын фракцуудын ашиг сонирхлын зөрчил, хоорондын үл ойлголцол нь төрийн ажлыг саатуулах, удаашруулах цаашлаад сэргөөр нөлөөлөх аюултай болж байна. Улс төрч хүн,

² Авлигын эсрэг хуулийн нэгдүгээр бүлгийн 4-р зүйлд нийтийн албан тушаалтанг:

- Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан
- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч,
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан,
- Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал,
- Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан,
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч,
- Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч,
- Эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан гэж заасан.

улс төрийн намын фракц нь улс орны эрх ашгийн төлөө ажиллах ёстой байтал хувийн эрх ашгийн төлөө ажиллаж, үл ойлголцох явдал нь улс орны тогтвортой байдал цаашлаад үндэсний аюулгүй байдалд хүчтэй нөлөөлөх асуудал болжээ. Гадаадын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, түүнийг татахад нэн тэргүүнд хувь улс төрчийн ашиг сонирхлыг багасгах тал дээр гол анхаарлаа хандуулан ажиллах шаардлага зайлшгүй тулгамдаж байна.

Улс төр судлаач, доктор Д.Ундрах “Парламентын ёс зүйн төлөвшлийн асуудалд” бүтээлдээ манай оронд түгээмэл болоод буй ашиг сонирхлын зөрчлийн нийтлэг шалтгааныг эдийн засгийн харилцаанаас эхлэлтэй, нийгэм улс төрийн харилцаанаас хамааралтай, нийгмийн ёс суртахуунаас үүдэлтэй (Ундрах.Д, 2015, хууд. 122) гэж гурван бүлэгт хувааж үзжээ. Энэхүү диссертацийн ажлын хүрээнд хийгдсэн социологийн судалгааны үр дүнд Гадаадын хөрөнгө оруулалтын санхүүжилт улс төрчдийн сонирхлыг татдаг гэсэн хариулт нь хувь улс төрчийн ашиг сонирхол бодлогын хэрэгжилтээс илүү давамгайлж буйг илэрхийлэх нэг үндэс юм гэсэн дүгнэлт хийсэн байдаг.

Улс төрчийн хувийн ашиг сонирхол, улс төрийн намын фракцуудын ашиг сонирхлын зөрчил нь засгийн газрын тогтворгүй байдалд нөлөөлж улмаар төрийн бодлогын залгамж чанар алдагдахад хүргэж байна. Эдгээрээс үүсэн дараах сөрөг үр дагавар бий болж байна. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа алдагдаж, гадаадын хөрөнгө оруулагчдад улс төрийн нөхцөл байдал тодорхойгүй, ойлгомжгүй харагдах болж хөрөнгө оруулалтын бодлого, чиглэл нь засгийн газар солигдох бүр ялгаатай болж, өмнө гарсан шийдвэрүүдийг өөрчлөх байдлаар явж ирсэн. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах тэргүүлэх чиглэл, эрэмбэ байхгүйн улмаас улс төрийн фракц, бүлэглэлийн ашиг сонирхолд нийцсэн төсөл хөтөлбөрийг дэмждэг тогтолцоо бий болж байна. Ажлын байр, эдийн засгийн тогтвортой өсөлтөөс илүүтэй тухайлсан бизнесийн бүлэглэл, хувь улс төрчийн ашиг сонирхолд нийцүүлсэн хөтөлбөрийг баталж, талуудын хамтын ажиллагаа, оролцоог тэгш хангах тал дээр анхааран ажиллахгүй байна.

Засгийн газрын тогтворгүй байдал ихсэх нь олон улсын зээлжих зэрэглэлийг бууруулж хөрөнгө оруулалтын орчинд муугаар нөлөөлөхийг Монгол улсын Хөгжлийн банк дурдсан байна. “2014 оны 4 дүгээр сард S&P (Standard and Poor's) мөн 2014 оны 7 дугаар сард Moody's агентлагууд Монгол улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан явдалд улсын хөрөнгө оруулалтын орчин болон улс төрийн тогтворгүй байдал шууд нөлөө үзүүлсэн

билээ. Улмаар, 2014 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр "Улсын их хурлаар Монгол улсын Ерөнхий сайдыг огцруулах асуудлаар хэлэлцэнэ" гэсэн мэдээлэл олон улсын мэдээллийн хэрэгслүүдээр цацагдсан бөгөөд 2014 оны 11 дүгээр сарын 6-ний өдөр Ерөнхий сайдыг огцруулсантай холбоотойгоор засгийн газрын 2022 онд дуусах бондын үнэ хоёрдогч зах зээл дээр 90.1 ам.доллараас 88 ам.доллар, 2018 онд дуусах бондын үнэ 95.5 ам. доллараас 94.4 ам. доллар хүртэл даруй буурсан байна. Өөрөөр хэлбэл нийгэм болон улс төрийн тогтворгүй байдал нь улсын эдийн засагт сөргөөр нөлөөлнө”³ гэж Монгол улсын Хөгжлийн Банк тодорхойлсон байна.

3 Хөгжлийн Банк (2017). Хөрөнгө оруулалгчид улс төрийн тогтвортой байдлыг голчлон анхаардаг. www.dbm.mn